



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Консерваторийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч дахин төлөвлөлтөд хамрагдаж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, 3 нэрийн, нийт 1,355,650,878.11 (нэг тэрбум гурван зуун тавин таван сая зургаан зуун тавин мянга найман зуун далан найман төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 453,255,634.88 (дөрвөн зуун тавин гурван сая хоёр зуун тавин таван мянга зургаан зуун гучин дөрвөн төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Монгол Улсын Консерваторийн захирал Ц.Шаравцэрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

1320014 0

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 06 дугаар сарын 13 ны өдрийн  
33.7 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| №                   | Хөрөнгийн нэр, марк                                  | Ашиглалтад орсон он | Тоо хэмжээ | Балансын үнэ (төгрөг)                                                                                                                   | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                                                                                  | Үлдэгдэл өртөг (төгрөг)                                                                                              |
|---------------------|------------------------------------------------------|---------------------|------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Барилга, байгууламж |                                                      |                     |            |                                                                                                                                         |                                                                                                                                 |                                                                                                                      |
| 1                   | Хичээлийн байр-1-ын хэсэг /урлаг заал, бүжгийн заал/ | 1962-01-01          | 1670.59    | 294,940,599.00                                                                                                                          | 178,438,999.00                                                                                                                  | 116,501,600.00                                                                                                       |
| 2                   | Хичээлийн байр-дуулаач                               | 2006-01-01          | 573.48     | 363,704,361.16                                                                                                                          | 50,225,840.08                                                                                                                   | 313,478,521.08                                                                                                       |
| 3                   | Дотуур байр-оюутны                                   | 1972-01-01          | 2578.99    | 697,005,917.95                                                                                                                          | 224,590,795.80                                                                                                                  | 472,415,122.15                                                                                                       |
| Нийт дүн            |                                                      |                     | 4823.06    | 1,355,650,878.11<br>(нэг тэрбум гурван зуун тавин таван сая зургаан зуун тавин мянга найман зуун далан найман төгрөг арван нэгэн мөнгө) | 453,255,634.88<br>(дөрвөн зуун тавин гурван сая хоёр зуун тавин таван мянга зургаан зуун гучин дөрвөн төгрөг наян найман мөнгө) | 902,395,243.23<br>(есөн зуун хоёр сая гурван зуун ерэн таван мянга хоёр зуун дөчин гурван төгрөг хорин гурван мөнгө) |